

БНЭУ-ын Ахмадабад хотод “Сансрын цаг агаар” сэдэвт богино хугацааны олон улсын сургалтад хамрагдсан товч тайлан

Улаанбаатар

2023.01.05

Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл үйлчилгээний хэлтсийн Синоптик инженер Х.Агиймаа 2022 оны 12 сарын 20-ноос 30-ны хооронд БНЭУ-ын НҮБ-д харьяалагдах Ази, Номхон далайн сансрын шинжлэх ухаан, технологийн боловсролын төв (CSSTEAP), БНЭУ-ын Засгийн газрын Сансар судлалын салбарын харьяа Физик судалгааны лаборатори (PRL)-оос зохион байгуулсан “Сансрын цаг агаар” сэдэвт богино хугацааны олон улсын сургалтад хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь сансрын цаг агаарт нөлөөлж буй нарны эх үүсвэрүүд болох нарны цацраг, титмийн массын ялгаралт, нарны энергийн тоосонцор болон тэдгээрийн хиймэл дагуул, харилцаа холбооны систем дэх дэлхийн ойр орчимд үзүүлэх нөлөөллийн тухай ойлголттой болох явдал юм.

Уг сургалтыг БНЭУ-ын Ахмадабад болон Удайпур хот дох Физик судалгааны лаборатори (PRL)-ийн доктор багш нар удирдан чиглүүлж, Ахмадабад хотноо танхимаар болон цахимаар PPT (Удайпур хотоос) заасан бөгөөд Бангладеш, Казахстан, Киргиз, Монгол, Мьянмар, Непал, Тажикстан, Узбекистан, Шри Ланка, Энэтхэг, Этиоп зэрэг нийт 11 орны 21 оролцогч хамрагдсан.

Сургалтыг Физик судалгааны лабораторийн захирал, Олон улсын сансар судлалын академийн академич Доктор Анил Бхардваж оролцогчдод амжилт хүсэж нээснээр эхэлж, цаашлаад сургалтад оролцогчид тус тусын ажил үүргийн талаар бусад хүмүүст товч танилцуулсан.

Сургалт нь нийт 25 цагийн лекц бүхий дараах сэдвүүдийн хүрээнд явагдсан. Үүнд:

1. Сансрын цаг агаарын тойм (2 цаг)
2. Сансрын цаг агаарын нарны эх үүсвэрүүд: Нарны бүтэц, наран дээрх үйл явц, түүний агаар мандал, нарны толбо, нарны идэвхжил, эрчим хүчний үйлчлэл түүний гарал үүсэл, нарны туяа, титмийн массын ялгаралт, нарны цацрагийн урт ба богино хугацааны өөрчлөлт (9 цаг)
3. Гелиосферийн цахилгаан соронзон ба цэнэгтэй бөөмсийн тархалт (2 цаг)
4. Дэлхийн соронзон мандал, ионосфер, термосферийн сансар огторгуйн цаг агаарт үзүүлэх хариу үйлдэл: Нарны цацраг, тоосонцортой харилцах үр дагавар (9 цаг)
5. Агаар мандлын дунд үе дэх процесст үзүүлэх нарны нөлөөлөл (1 цаг)
6. Сансрын цаг агаарын электрон болон холбооны системд үзүүлэх нөлөө (2 цаг)

12-р сарын 22-оос 25-ны өдрүүдэд сургалтын үеэр оролцогчид Удайпур хотын нарны ажиглалтын төв (USO), Mt Abu хот дох оптик аэрномийн лаборатори болон физик судалгааны төрөл бүрийн лабораторид зочлон зарим багаж хэрэгслүүд, тэдгээрийн өгөгдлийг практикт ашиглах туршлага хуримтлуулсан.

Дүгнэлт: Энэхүү олон улсын сургалт нь миний хувьд бүхий л талаараа шинэлэг байсан бөгөөд олон талын ач холбогдолтой мэдээ, мэдээлэл өгсөн үр дүнтэй сургалт болсон. Мөн бусад улс орнуудын уг сургалтын сэдэвт холбогдох салбар бүрд ажиллаж байгаа цаг уурчид, физикч, их сургуулийн багш нар, докторантууд болон Энэтхэгийн агаарын нисэх хүчний командлагчид нартай туршлага солилцож, мэдээлэл хуваалцсан ололттой байсан. Сургалтад хамрагдсанаар бид нарны цацрагийн гараг хоорондын орчин болон түүнд үзүүлэх нөлөөллийн талаар ерөнхий ойлголттой болсон. Мөн сансрын цаг агаарын таагүй нөхцөл байдал радио холбоо, хиймэл дагуулын системд хэрхэн нөлөөлж байгаа талаар мэдлэгтэй болсон. Дэлхийн хувьд сансрын цаг агаарын сөрөг нөлөөллөөс шалтгаалж соронзон мандал, ионосфер, термосферт орон зай, цаг хугацааны өөрчлөлтүүд үүсдэг. Нарны салхи болон цацраг нь сансрын болон газар дээрх харилцаа холбооны системүүдийн электроникийн эвдрэлд хүргэж болзошгүй байдаг байна. Тиймээс сансрын цаг агаар нь дэлхий дээрх амьдралд маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд орчин үеийн нийгмийн бараг бүх салбарт нөлөөлдөг. Сансрын цаг агаарын талаар тодорхой ойлголттой байх нь орчин үеийн соёл иргэншлийн зайлшгүй шаардлага болжээ.

Тайлан бичсэн:

НЦУТ-ийн синоптик инженер

*А. Агиймаа*

Х.Агиймаа



Физик судалгааны лаборатори (PRL), Ахмадабад хот, БНЭУлс

2022.12.30